

МӨРДӨГЧИЙН АЖЛЫН АЧААЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Б.Шинэ-Од.

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч, магистрант, цагдаагийн хошууч.

Д.Булган.

ДХИС-ийн Удирдлагын академийн ЦУСПБ-ийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, хөдөлмөрийн цагийн хуваарилалт, үйл ажиллагааны зохион байгуулалт муу байгаа талаар олон судалгаануудад дурдагдсаар ирсэн. Тиймээс энэхүү нийтлэлээр цагдаагийн байгууллагын мөрдөгчийн ажлын ачааллын өнөөгийн байдлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга замыг эрэлхийллээ.

Түлхүүр үгс. мөрдөгч, ажлын ачаалал, эрүүгийн хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.

Оршил. Цагдаагийн байгууллагын хамгийн үнэ цэнтэй нөөц бол цагдаагийн алба хаагчид юм. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг, тавьсан зорилтоо биелүүлж, стратегия хэрэгжүүлэхийн тулд хүний нөөцийн удирдлагыг зөв хэрэгжүүлэх нь чухал юм. Цагдаагийн байгууллагад хүний нөөцийн тогтвор суурьшил, ажлын ачаалал, ажилтны хандлага, сургалт, хөгжилтэй холбоотой хүний нөөцийн бодлого боловсруулахад хүндрэлтэй байх нийтлэг асуудлууд ажиглагддаг. Жишээлбэл, шинээр томилогдсон алба хаагчид цагдаагийн байгууллагад ажиллаж эхлээд нэг жил хүрэхгүй ажиллаад гарах тохиолдлууд сүүлийн жилүүдэд нэмэгдсэн. Энэ нь цагдаагийн ажил Хөдөлмөрийн хуульд заасан ажлын цагаар ажилладаггүй, илүү цагаар байнга ажилладаг, ачаалал ихтэй, цалин бага, дарга удирдлагуудын удирдах ур чадвар муу, зохион байгуулалт муу, алба хаагч ур

чадвараа хөгжүүлэх боломж бага, ямар үр дүн гаргавал албан тушаал өсөх буюу зэрэглэл нэмэгдэх зэрэг мэдээлэл тодорхойгүй зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна.

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, хөдөлмөрийн цагийн хуваарилалт, үйл ажиллагааны зохион байгуулалт муу байгаа талаар олон судалгаануудад дурдагдсаар ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс 2014 онд Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцын заалтыг хэрхэн биелүүлж байгааг судалсан юм. Цагдаагийн байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалж, урьдчилан сэргийлж, хүний аюулгүй, амар тайван амьдрах баталгааг бүрдүүлэх чиг үүрэгтэй бөгөөд тус байгууллагад үүрэг гүйцэтгэж буй

алба хаагчдын хөдөлмөрлөх эрх зөрчигдөх эрсдэл өндөртэй бүлэгт хамаардаг гэж үзсэн.

Энэхүү тайланд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын цагийг баримтлан ажиллахад 1 ажилтан сард 160 цаг, жилд 1760 цаг ажиллах ёстой боловч нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч 7 хоногийн 6 өдөр буюу хамгийн багадаа сард 192 цаг, жилд 2112 цаг ажиллаж байна. Гэтэл тэд жилд хамгийн багадаа 352 цаг илүү цаг ажиллаж байна. Үүнд шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр ажиллуулсныг тооцоогүй болно. Замын цагдаагийн газрын Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хэлтсийн даргын баталснаар дүүргүүд дэх замын цагдаагийн тасгийн хэрэг бүртгэгч, бүсийн эргүүлийн зохицуулагч, цагдаа зохицуулагч нар дараах хуваарийн дагуу ажиллаж байна. Үүнд:

- 1 дүгээр ээлж 07.00 цагаас 15.00 цаг хүртэл
- 2 дугаар ээлж 15.00 цагаас 23.00 цаг хүртэл
- Шөнийн эргүүл 20.00 цагаас 08.00 цаг хүртэл
- Хэрэг бүртгэгч 08.00 цагаас 17.00 цаг хүртэл

Мөн бүсийн эргүүлийн зохицуулагч, цагдаа зохицуулагч нар 7 хоногийн 6 өдөр ажиллаж байх ба амралтын аль нэг өдөр уртасгасан цагаар буюу 12 цаг ажиллаж байна. Замын цагдаагийн алба хаагч жилд дунджаар 2288 цаг ажиллаж, үүнээс 528 цаг илүү цагаар ажиллаж байна¹.

Мөн “Maxima” судалгааны төвөөс хийсэн “Цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөл, боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын талаарх судалгааны тайланд алба хаагчид үндсэн чиг үүрэгт заасан ажлаа хийхэд ажлын хуваарьт цаг хүрэлцдэггүй, захиргааны болон нийтлэг чиг үүргийн ажилд их цаг зарцуулдаг, зарим албан тушаалын хувьд дийлэнх цагийг зарцуулдаг, ажлын ачаалал хэт их байгаа талаар дурдсан. Энэ судалгаанд нийт 37 нэгжийн 1000 алба хаагч буюу нийт бие бүрэлдэхүүний 10 орчим хувь нь хамрагдсан байна.:

Судалгаагаар ажлын ачаалал нэмэгдүүлж байгаа дараах нийтлэг зүйл байна:

- Цаг үеийн онцгой нөхцөл байдал /Ковид-19, цар тахал, жагсаал, цуглаан, баяр ёслол, өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчдийн хамгаалалт/;
- Ажлын цагаар зохион байгуулдаг хурал;
- Дээд шатны байгууллагаас ирүүлсэн “нэн яаралтай”, “яг одоо хариу өгөх” албан бичиг, танилцуулга, мэдээллийн боловсруулалт;
- Байнгын дутуу орон тоогоор ажилладаг хүний нөөцийн буруу тогтолцоо;
- Цагдаагийн байгууллагын алба, нэгжийн буруу бүтэц зохион байгуулалт, давхардал;
- Ажлын цагаар зохион байгуулдаг үр өгөөжгүй сургалтууд;

¹ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх

илтгэл. МУ-ын Хүний эрхийн Үндэсний комисс. УБ., 2014.

- Улс төр, төрийн захиргааны байгууллагаас гаргасан буруу шийдвэр (жишээлбэл утаа хянах, газар чөлөөлөх зэрэг бусад байгууллагатай хамтарсан хяналт шалгалт гэх мэт);
- Шинэ боловсон хүчин ажилдаа дадлагажих хугацааны нэмэлт ачаалал;
- Удирдлагын оновчгүй зохион байгуулалт, шийдвэр;
- Удирдах буруу арга барил;
- Шүүх, прокурорын зохиомол ачаалал;
- Эрх зүйн орчны өөрчлөлт зэргийг дурджээ¹.

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их байгаа талаар 2014, 2022 оны дээрх судалгаануудаас харагдаж байна. Тэгвэл эдгээр онуудад гэмт хэргийн

нөхцөл байдал ямар байсныг гэмт хэргийн статистик мэдээнээс судалж үзье. Дараах зургаас харахад 2015 онд улсын хэмжээнд 27757 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд 17939, орон нутагт 9818 гэмт хэрэг гарчээ. Харин 2022 онд иргэн, аж ахуйн нэгжээс 657.650 дуудлага мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 309.572 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 42.351 буюу 15.8 хувиар өсөж, гэмт хэргийн шинжтэй 97.007 /31.3%/, зөрчлийн шинжтэй 206.840 /66.8%/ гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байна².

Дараах зургаар 2014-2022 оны гэмт хэргийн нөхцөл байдал, өсөлт, бууралтыг графикаар харууллаа.

Зураг №01. Гэмт хэргийн 2013-2022 оны статистик



Дээрх зургаас харахад цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг 2014 оноос хойш өссөн үзүүлэлтэй байх байх бөгөөд 2018 оноос ялимгүй буурсныг ковидын

нөхцөл байдал, хөл хорионы нөхцөл байдалтай холон тайлбарлаж болохоор байна. Улс орон даяар зарласан хөл хорио тавигдсанаар гэмт хэрэг дахин өссөн үзүүлэлтэй

¹ Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний тайлан. "Максима Консалтинг" ХХК. УБ., 2022 он.

² Цагдаагийн байгууллагад 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. ЦЕГ., 2023.

байна. Дээрх гэмт хэргийн нөхцөл байдал, статистик тоо, цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалалтай холбоотой судалгааг харьцуулан үзэхэд цаашид ч цагдаагийн алба хаагчийн ачаалал цаашид нэмэгдэхээр төлөвтэй байна.

Үндсэн хэсэг. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллыг зүй зохистой байлгах, ажлын чанарыг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг баталсан. Энэхүү нормативд хэсгийн

төлөөлөгч, цагдаа сум болон төмөр замын зангилаа бүрд 9, эрүүгийн төлөөлөгч, цагдаа нийслэлийн хороо бүрд 1 байхаар тусгасан.

Мөрдөн байцаагч. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсүүдэд 2022 оны 11 сарын байдлаар орон нутагт буюу 21 аймагт нийт 108, нийслэлийн 17 хэлтсийн 107 алба хаагч ажиллаж, 45728 хэрэг шалгаж, дунджаар нэг алба хаагч сард 10 эрүүгийн хэрэг ногдож байна¹. Энэ нь 2002 оны Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль мөрдөгдөж байх үеийнхээс даруй 3-4 дахин их ачаалалтай болсныг харуулж байна. Үүнийг дэлгэрүүлэн дараах хүснэгтээр харууллаа.

Нэгжийн нэр	Ажилласан мөрдөгчийн тоо	Нийт ХБ хэрэг	ХБ шийдвэрлэлт	Нийт МБ хэрэг	МБ шийдвэрлэлт	Нийт мөрдсөн хэрэг	Нэг мөрдөгчийн сард мөрдсөн хэрэг	Нийт шийдвэрлэлт	Нэг мөрдөгчийн сард шийдсэн хэрэг	Одоо ажиллагаанд байгаа		Нийт үлдэгдэл
										ХБ хэрэг	МБ хэрэг	
Орон нутаг	108	6685	6080	8185	7978	14870	12.5	14058	7	605	207	812
Нийслэлд	107	21499	16952	15118	14718	36617	31.1	31670	13	4547	400	4947
Улсын дүн	215	28184	23032	23303	22696	51487	21.8	45728	10	5152	607	5759

Хүснэгт №02. Мөрдөгчийн 2022 онд шалгасан хэргийн тоо

Хүснэгтээс харахад орон нутагт нийт хэрэг бүртгэлтийн хэрэг 6685, мөрдөн байцаалтын хэрэг 8185 бөгөөд нийт 14870 хэрэг мөрдсөн бөгөөд сард дунджаар нэг алба хаагч 12.5 хэрэг шалгасан байна. Үүнээс сард нэг алба хаагч дунджаар 7

хэргийг бүрэн шийдвэрлэсэн байна. Харин нийслэлд хэрэг бүртгэлтийн хэрэг 21499, мөрдөн байцаалтын хэрэг 15118 хэрэг шалгасан бөгөөд нэг алба хаагч дунджаар 31.1 хэрэг мөрдсөн байна. Үүнээс шийдвэрлэсэн хэрэг дунджаар 13

¹ Мөрдөн байцаах албаны 2022 оны ажлын ачааллын судалгаа.

хэрэг байгаа нь орон нутгийн алба хаагчидтай харьцуулахад 2.5 дахин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Нийслэлийн нийт мөрдөгчдийн 33.4% нь ямар нэг байдлаар шилжилт, хөдөлгөөн хийгдсэн бол орон нутагт мөрдөгчид харьцангуй тогтвортой ажиллажээ. Дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн мөрдөгчдийн 70.0 орчим хувь нь 2 жил хүртэл, 10% нь 5 жил хүртэл хугацаанд мөрдөгчөөр ажилласан туршлагатай, орон нутагт мөрдөгчдийн 45% нь 2 жил хүртэл, 35.% нь 5 жил хүртэл хугацаанд мөрдөгчөөр ажиллаж байгаа судалгаа гарсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа алба хаагчдын хувьд туршлага багатай нийтлэг байдал ажиглагдаж байна¹.

Мөрдөн байцаах албаны алба хаагчдын ажлын ачаалалд сүүлийн 2 жилийн байдлаар судалгаа, дүн шинжилгээ хийхэд 2020 оны эхний хагас жилийн байдлаар 23055 хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж 18553 хэрэг буюу 80.4%-ийг шийдвэрлэж, нэг мөрдөгч дунджаар 53.6 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Мөрдөн байцаах албаны хэмжээнд нийт 51 алба хаагчийн орон дутуу байгаа нь мөрдөгчийн ажлын ачаалалд шууд нөлөөлж байна².

Эрүүгийн мөрдөгч. Нийслэл, аймгуудын цагдаагийн газруудын Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нарын хүн хүчний тооцоог Эрүүгийн цагдаагийн албаны хүний нөөцийн сантай, бүртгэгдсэн хэргийн тоог цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээн

дээр үндэслэн мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачааллын талаарх дүн шинжилгээг хийлээ.

Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхлэхэд тодорхой хүндрэл, бэрхшээл үүсэж байсан. Тухайлбал, хуулийг практикт нэг мөр хэрэгжүүлэх ойлголт муу, ойлголтын зөрүүгээс болж хуулиа буруу хэрэглэх, гомдол, мэдээлэл шалгах хугацаа нь зарим ажиллагааг бүрэн гүйцэт хийж гүйцэтгэхэд хүрэлцдэггүй байсныг 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр албаны дарга 14 хоног сунгах нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Мөн алба хаагчдын мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэргийн тоо өссөнөөс хэрэг тус бүрд хүрч ажиллахад хүндрэлтэй болсон төдийгүй, удирдлагын зүгээс шинэ хэрэгжиж буй хуулийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаагүйгээс эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачааллыг бууруулах чиглэлээр шалгарсан туршлага, арга барил дутагдаж байна.

Цагдаагийн байгууллагад ирсэн өргөдөл гомдлын холбогдогч этгээд тодорхой, тодорхой бусаас хамаарч, мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, эрүүгийн цагдаагийн тасгийн мөрдөгч алба хаагчдыг томилон шалгуулдаг, ингэхдээ гэмт хэргийн шинжтэй эсэхийг тодорхой шалгаж тогтооход цаг хугацаа, техник, хэрэгсэл зарцуулсны дараа гэмт хэргийн шинжгүй гэж үзэж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж байгаа байдал нь мөрдөгчийн ачааллыг бий болгох нэг хүчин зүйл болж байна.

Эрүүгийн хууль (2015 он) хэрэгжиж эхлэхээс өмнө нийслэлд

¹ Мөрдөн байцаах албаны судалгаа. УБ., 2021 он.

² Мөрдөн байцаах албаны тайлан. УБ., 2022 он.

нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 5 хэрэг, орон нутгийн эрүүгийн мөрдөгч сард 2 хэрэг шийдвэрлэж гүйцэтгэх ажлын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулах, бусад арга хэмжээ зохион байгуулж байсан бол 2017 оны 07 дугаар сарын 01-нээс эхэлснээс хойш нийслэлд ажиллаж байгаа нэг эрүүгийн мөрдөгч сард дунджаар 7-8 хэрэг, орон нутагт ажиллаж байгаа эрүүгийн мөрдөгч сард 3 хэрэг шийдвэрлэж мөн давхар хэрэг бүртгэлтийн 60-180 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Үүнээс үзвэл, эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачаалал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээс хойш

нийслэлд 2-3 нэгжээр буюу 40 орчим хувиар өссөн, орон нутагт 1 нэгжээр буюу 20 орчим хувь өссөн байна.

ЦЕГ-ын дарга 2019 оны 06 сарын 21-ний өдөр эрүүгийн мөрдөгч, мөрдөгчийн албан тушаалын тодорхойлолтыг баталсан. Энэхүү албан тушаалыг тодорхойлолтыг боловсруулахдаа төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шалгуур¹-ыг баримтлан боловсруулсан. Энэ хүрээнд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах тасаг, хэсгийн мөрдөгчийн албан тушаалын тодорхойлолтыг зүйл заалт тус бүрд дүн шинжилгээ хийв.

Хүснэгт №03. Ажлын байрны тодорхойлолтын харьцуулалт

Эрүүгийн мөрдөгч	Мөрдөгч
Албан тушаалын зорилго	
Хариуцсан чиглэл, нутаг дэвсгэрт нууц, далд аргаар үйлдэгдсэн болон хуулиар харьяалуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж, шийдвэрлэх Монгол Улсын хууль, хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, хуулиар хүлээсэн бусад үүргээ хэрэгжүүлэх.	Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан харьяалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах
Албан тушаалын зорилт	
1. Хариуцсан чиглэлээр нууц далд зохион байгуулалттай үйлдэгдэж байгаа гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулж баримтжуулан шалгах, нотлох баримт цуглуулах мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ; 2. Харьяалуулсан объект, чиглэлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй иргэн албан тушаалтны талаар судалгаа хийж, Гүйцэтгэх ажлын бүртгэлд оруулж, хяналт тавих; 3. Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн алба, тухайн цагдаагийн газар, хэлтсээс дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах; 4. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	1. Харьяалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах; 2. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах; 3. Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх; 4. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх тус тус тодорхойлсон.

¹ ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дэд бөгөөд дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга, цагдаагийн

хурандаа Б.Даваажавын 2022 оны 06 сарын 29-ний өдрийн 9/1-3416 дугаартай албан бичгийн хавсралт.

Дээрх хүснэгтээс харахад мөрдөгчийн ажлын байрны тодорхойлолтын зорилтын 1 дэх хэсэгт мөрдөгч харьяалах гэмт хэрэгт “мөрдөн байцаалт”-ын ажиллагаа явуулахаар заасан нь зөвхөн прокуророос “эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан хэрэгт л эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар заасан” байна. Харин эрүүгийн мөрдөгч хариуцсан нутаг дэвсгэртээ нууц, далд аргаар үйлдэгдсэн ... гэмт хэргийг илрүүлэх хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж, шийдвэрлэхээр заасан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эсэх нь ойлгомжгүй байна. Мөн эрүүгийн мөрдөгчийн 1 зорилтын хүрээнд 1.1, 1.2-д зааснаар Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын заавар журмыг баримтлан мэдээ, мэдээлэл цуглуулах, ... мэдээллийн санд бүртгэн шалгаж шийдвэрлэх талаар заасан. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулахаас гадна гүйцэтгэх ажил явуулахаар тусгасан байна.

ЦЕГ-ын даргын 2017 оны 06 сарын 30-ны өдрийн ... дугаартай тушаалаар мөрдөн байцаах тасгийн мөрдөгч нь зөвхөн эзэнтэй буюу гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тодорхой хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар дурдсан. Энэ баримт бичгийн хүрээнд бол ЦЕГ-ын МБА-ны мөрдөгч зөвхөн эзэн холбогдогч нь тодорхой буюу прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан мөрдөн байцаалтын хэрэгт л мөрдөн шалгах ажиллагаа явуулах ёстой ч байгууллагын онцлог, харьяалах прокурорын нэгжийн үзэмжээс хамаарч харилцан адилгүй

зохицуулагдаж байна. Энэ нь мөрдөн шалгах үйл ажиллагаа цагдаагийн байгууллагад нэгдсэн хэлбэрт шилжээгүй, хуулийн хэм хэмжээнээс үл хамаарсан шалтгааны улмаас харилцан адилгүй хэрэгжиж байгаа гэж үзэж болно.

Эрүүгийн мөрдөгч болон мөрдөгч албан тушаалын тодорхойлолтын хөдөлмөрийн ажлын цагийн 8 цаг болон хөдөлмөрийн “хэвийн” нөхцөлтэй гэж заасан. Гэтэл эрүүгийн мөрдөгчийн хувьд цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж байна. Гүйцэтгэх ажлын хүрээнд эзэн холбогдогч нь тодорхойгүй, нууц, далд аргаар үйлдсэн, сэжигтэн, яллагдагчийг оргон зайлсан үед эрүүгийн мөрдөгч өдөр, шөнөгүй хайх, эрэн сурвалжлах, гүйцэтгэх ажил явуулдаг. Энэ нь мөрдөгчтэй харьцуулахад ажлын ачааллыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

Мөрдөгчийн ажлын ачаалал, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлохоор 30 мөрдөгчидтэй уулзаж, фокус ярилцлага хийлээ. Эрүүгийн мөрдөгч болон мөрдөгчтэй фокус ярилцлага хийхэд дараах нийтлэг тулгамдсан асуудал байгаа талаар дурдсан. Үүнд:

- Мөрдөгч ажлын 8 цагтаа төлөвлөсөн ажлаа хийж, хэргээ шалгаж чаддаггүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд ажлын 8 цагт багтдаггүй бөгөөд байнга төлөвлөснөөс өөр ажил гарч, ажлын хугацаандаа үндсэн чиг үүргээ гүйцэтгэж чаддаггүй гэж 90 хувь нь

хариулсан. Мөн хэлтсийн орон тоо дутуу нэг хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасаг, мөрдөн байцаах тасагт 4 орчим орон дутуу хэлбэлзэлтэй байнга явдаг.

Ажлын байрны сургалт, долоо хоногийн өдрийн 15 цагийн рапорт хийх байдал нь ажлын дундуур зохион байгуулагддаг нь төлөвлөсөн ажлыг үр дүнгүй. Зохион байгуулалтын хувьд зохимжгүй байдаг. Учир нь өдрийн цайны цагийн дараа ажлыг төлөвлөж хэрэгжүүлэхэд саад болдог.

- Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг сайжруулах;

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн хувьд ЭЦА, МБА, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад эрүүгийн цагдаагийн тасаг, мөрдөн байцаах алба тус тус ажиллаж байна. Өмнөх зохион байгуулалтын бүтцээр Хэрэг бүртгэх алба ажиллаж байсныг татан буулгаж, Зөрчлийн хэрэг бүртгэх газар байгуулагдсан. Энэ нь хэрэг бүртгэгч нар хэрэг бүртгэлтийн хэргийг шийдвэрлэхгүй, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарт шууд ачаалал болсон.

- Хүний нөөцийн хомсдолтой, энэ чиглэлээр хийгдсэн арга хэмжээ байхгүй;

Дүүргийн Эрүүгийн цагдаагийн тасаг 4 хүний орон тоо, Мөрдөн байцаах тасагт 3 алба хаагчийн орон тоо тус тус дутуу байгаа талаар ярилцаж байлаа. Сүүлийн хугацаанд мөрдөгчийн ажлын онцлог, ачааллаас хамаарч Мөрдөн байцаах албаны мөрдөгчөөр ажиллах дур сонирхолтой албан хаагчид ховордсон, олон алба хаагчид өөрийн хүсэлтээр

чөлөөлөгдсөн, албан тушаалаа өөрчилсөн талаар мэдээлэл, мөрдөгч нартай хийсэн фокус ярилцлагын үр дүнд тодорхой харагдаж байна.

- Мөрдөгчийн бие даасан, хараат бус, халдашгүй байх зарчим хуульчлагдаагүй.

Эрх зүйн зохицуулалтын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зарим зохицуулалтыг сайжруулах талаар алба хаагчид дурдаж байв. Тухайлбал, Эрүүгийн мөрдөгч, мөрдөн байцаагчийн зааг ялгааг тодорхой зохицуулж өгөх, эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх талаар тусгах талаар ихэнх мөрдөгч нар дурдаж байна.

- Удирдах албан тушаалтны мэдлэг, ур чадвар хангалтгүйн улмаас үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулдаггүй.
- Мөрдөх чиг үүргийн алба хаагчид тогтвор суурьшилгүй ажилладаг, удирдлага нь бие даасан шинжгүй, тогтвортой бус, үүнийгээ дагаад шийдвэр, үйл ажиллагаа нь байнга өөрчлөгдөж байдаг,
- Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа уламжлалт хэлбэрээр явагддаг, хуучин арга барилаар мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг, орчин үеийн техник хэрэгсэл ашигладаггүй;
- Мөрдөгчид ажлын байрны сэтгэл ханамжгүй байгаа нь ажлын гүйцэтгэлд нөлөөлж, үйл ажиллагаандаа хайхрамжгүй хандах зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Бид судалгааны ажлын хүрээнд эрүүгийн мөрдөгч, мөрдөгчийн үйл ажиллагааг судалж авч үзсэн хэдий ч цагдаагийн байгууллагад жижүүрийн ахлах мөрдөгч¹, хэсгийн төлөөлөгч², эдийн засгийн мөрдөгч³, алба, газрын чиглэлийн ахлах мөрдөгч⁴ гэсэн өөр нэршилтэй мөрдөгчид байна. Эдгээр алба хаагчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаггүй байна. Тиймээс үйл ажиллагааны зохион байгуулалтыг судалж, дүн шинжилгээ хийх, сайжруулах шаардлагатай байна. Мөн мөрдөгчид ЦЕГ-ын даргын 2020 оны 10 сарын 10-ны өдрийн А/258 дугаартай Эрх олгох тухай тушаалаар “зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа” явуулах эрх олгосон нь ажлын ачаалал нэмэгдүүлэх нэг үндэслэл болсон.

Дүгнэлт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гэмт хэргийг бүрэн дүүрэн, шуурхай илрүүлэх, нотолж ял шийтгэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ажиллагааг явуулахад цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц тогтолцоо нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажил явуулахад чиглэсэн байна. Мөрдөгчийн эрх зүйн байдал нь цагдаагийн бусад алба хаагчдаас онцлог бөгөөд эрүүгийн процессын үйл ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд

заасан эрх, эдэлж, үүрэг хүлээх байдлаар илэрхийлэгдэж байна. Гэхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь прокурорын хяналтад хэрэгжиж байхаар зохицуулагдсан байгаа нь мөрдөгчийн ажлын ачаалалд шууд нөлөөлөхөөр зохицуулалт бүхий болжээ.

Мөрдөгчийн ажилд “оюуны болон нийгмийн ачаалал” ихээр үүсэж, ажлын гүйцэтгэлд шууд сөрөг нөлөөлөл бий болж байна. Тухайлбал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд хэргийг хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх боломж хомс байгаа нь цаг хугацааны дарамт буюу илүү цагаар ажиллах, ажлын цаг урт байх, ажлын гүйцэтгэлд сөрөг дарамт үзүүлдэг байна. Мөн нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, тухайлбал, хүн алах, хулгай хийх, залилах гэмт хэрэг үйлдэх зэрэг нь ажлын байранд сэтгэл зүйн стрессийг бий болгож байна.

Мөрдөгчийн ажлын ачаалалд гадаад болон дотоод хүчин зүйлс шууд нөлөөлж байна. Тухайлбал, мөрдөгчийн гэмт хэргийг мөрдөх ажиллагааны онцлог нь бие махбодын болон оюун санааны ядаргаа, толгой өвдөх, хоол боловсруулах эрхтний эмгэг, цочромтгой байдал зэрэг эрүүл мэндэд шууд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын ажлын ачаалал нь үүрэг гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж улмаар ажлаасаа халшрах, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх, албан тушаалаа өөрчлөх талаар хүсэлт гаргах,

¹ “Жижүүрийн ахлах офицер” байсан. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрхгүй.

² “Эрүүгийн төлөөлөгч” мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрхгүй.

³ “Эдийн засгийн төлөөлөгч” мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрхгүй.

⁴ Хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаггүй. Ажлын байрны тодорхойлолт мөрдөн байцаах тасгийн даргынхтай ижил боловч чиг үүрэг хэрэгжүүлдэггүй, боломжгүй.

албанаас халагдах, цаашлаад гэр бүлийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэлтэй болохыг судалгаа харуулж байна. Мөн мөрдөгчийн ажил үүрэг ачаалал хэт их, хариуцлага өндөртэй боловч цалин багатай, завгүй байдал нь албан тушаалаа өөрчлөх сонирхлыг бий болгож байна.

Мөрдөгчидтэй фокус ярилцлага хийж, ажлын байрны зураг авалт хийхэд мөрдөгчийн ажлын ачаалал их байгаа талаар 100 хувь санал нэгтэй хариулж байсан ба орон тоо дутуу, зохион байгуулалтын бүтэц оновчгүй, удирдлагын арга барил муу байхаас гадна эрх зүйн зохицуулалтын оновчгүй байдал шууд нөлөөлж байна. Тухайлбал, гэмт хэргийн статистик үзүүлэлт өссөн учраас хэрэг тус бүрд хэргийн хугацаа сунгах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах тохиолдол бүрд прокурорын зөвшөөрөл авах санал үйлдэж, хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд мэдүүлэг өгөгчийн байгаа газарт очиж мэдүүлэг авах зэрэг техник ачаалал хэт их байна.

Санал.

1. Мөрдөгчийн ажлын ачаалал үүсэхэд нөлөөлж буй эрх зүйн зохицуулалтыг сайжруулах. Тухайлбал, мөрдөгчийн зарим төрлийн үйл ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүйгээр явуулах боломжийг бүрдүүлэх. Энэ нь гэрч, хохирогч, шинжээч, сэжигтэн гэх мэт оролцогчоос мэдүүлэг авахад дуудан ирүүлэхэд прокурорын мэдэгдэх

хуудсаар дуудан ирүүлэх асуудал байдаг.

2. Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг мөрдөн шалгах чиг үүргийн алба хаагчдыг ажлын ачааллыг бууруулахад чиглэсэн олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эргүүл, жижүүр, хамгаалалтад татан оролцуулахгүй байх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлснээр мөрдөгчид ирэх ажлын хэт их ачаалал буурах нэг үндэслэл болохыг судалгаа харуулж байна.
3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 153 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын зарим ажил үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг тогтоож өгсөн бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд үүрэг бүхий алба хаагч нийт орон тооны 75.0 хувиас доошгүй байхаар тусгаснаас өөрөөр мөрдөгчийн жишиг нормативыг тогтоож өгөөгүй байна. Иймд ур чадварт тулгуурласан мэргэшлийг зэрэг олгох, мөрдөгчийн хэм хэмжээний стандарт, нормативыг тогтоох, чиг үүргийн давхардалгүй болгох, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, бууруулах эрх зүйн орчныг бий болгох.